



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 5/10

Хажуу шинэ ус

Д.Сарангэрэлд Засаг даргын Тамгын газрын
Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан
мэргэжилтний албан үүргийг түр орлон
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3, Засгийн газрын 2022 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газар нь Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн байхгүй байгаа тул Хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Дорждэрэмийн Сарангэрэлийг Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэнээр 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс түр орлон гүйцэтгүүлэхээр томилсугай.

2.Д.Сарангэрэл-д Засгийн газрын 2022 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу ТЗ-9 дахь шатлал 791,532.00 (Долоон зуун ерэн нэгэн мянга таван зуун гучин хоёр) төгрөгийн 40% болох 316,600.00 (Гурван зуун арван зургаан мянга зургаан зуу) төгрөгөөр цалинжуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (У.Сүнжидмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Албан үүргээ гүйцэтгэхдээ Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хориглолт хязгаарлалтуудыг баримтлан,бусад хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэж эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандан, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахин ажиллахыг (Д.Сарангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГТОХ



482305010